

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА, САНГИЙН САЙД, ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 3 дугаар сарын
сарын 29-ний өдөр

Дугаар А-82/157/68/A26


Улаанбаатар
хот

Замын зураг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 91 дүгээр тогтоолын 2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэ тушаалын 1-д заасан “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийн хэрэгжилтийг хангаж, байнгын хяналт тавин ажиллахыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч /Г.Энхтайван/, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга /Т.Жамбаажамц/, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Ганбат/, Хадгаламжийн даатгалын корпорацийн Дэд захирал /Х.Гэрэлт-Од/ нарт тус тус үүрэг болгосугай.

 <p>МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ</p>	 <p>САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА</p>	 <p>САНГИЙН САЙД</p>	 <p>ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ</p>
Б.ЛХАГВАСҮРЭН	Д.БАЯРСАЙХАН	Б.ЖАВХЛАН	С.БААТАРСҮРЭН

ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ҮНДЭСНИЙ ЗАМЫН ЗУРАГ

2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот
2022 он

Танилцуулга

Монгол Улс нь Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Алсын хараа 2050 зэрэг бодлогын хүрээнд 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 22.7 хувиар бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, амьдралын чанар, хүний хөгжлийг сайжруулж, чанартай боловсрол, сайн засаглалыг бий болгох замаар ногоон, нийгмийн хүртээмжтэй хөгжилд хүрэх зорилтыг тавьсан билээ. Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг биелүүлэхэд 11.7 тэрбум ам.доллар, харин Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд 2030 он хүртэл нэмэлтээр 43 тэрбум ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд бодлого санхүүжилтийн уялдааг хангасан үндэсний хэмжээний тогтвортой санхүүгийн бодлого, стратегийг тодорхойлох, өнөөгийн болон ирээдүйн санхүүжилтийн урсгалыг Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглүүлэх, олон талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, уялдуулах хэрэгцээ үүсэж байна. Түүнчлэн, тогтвортой хөгжил нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн тогтвортой хөгжил, хүртээмжийг бий болгох, шинэ зах зээлийн боломжуудыг нээхэд томоохон хувь нэмэр оруулах боломжтой юм. Үүнтэй холбоотойгоор Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлд тогтвортой санхүүгийн ач холбогдлыг онцлон “уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэх” зорилтыг тавьсан.

Үндэсний тогтвортой санхүүгийн замын зургийн үндсэн зорилго нь Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтуудтай уялдсан, нэгдмэл, олон талт хамт ажиллагааг хангасан, тогтвортой санхүүгийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх, бүс нутагтаа тогтвортой санхүүгийн мэдлэг, манлайллын төв болох, үүнд шаардлагатай стратегийн чиглэл, арга хэмжээг тодорхойлоход оршино.

Замын зураг нь үндсэн 6 бүлэг, 25 дэд арга хэмжээнээс бүрдсэн бөгөөд эдгээрийг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд банкны салбарын ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх, банкнаас бусад санхүүгийн байгууллагын олгосон нийт зээлийн багцын 5-аас доошгүй хувийг ногоон зээлээр бүрдүүлэх зорилтыг тавьж байна.

Уг баримт бичгийн төслийг боловсруулахад Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо), Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас өмнө боловсруулсан судалгаа, замын зураг, зөвлөмжийг ашигласан бөгөөд Европын Холбоо, БНХАУ, Индонез зэрэг бусад олон улсын сайн туршлагыг харгалзан боловсруулсан болно. “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөр батлах тушаалын төсөл, түүний хавсралтыг танилцуулж байна.



Зорилго: Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтуудтай уялдсан, нэгдмэл, олон талт хамт ажиллагааг хангасан, тогтвортой санхүүгийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх, ингэснээр бүс нутагаа тогтвортой санхүүгийн мэдлэг, манлайллын төв болох

Зорилт:

- 2030 он гэхэд банкны салбарын ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх.
- 2030 он гэхэд банкнаас бусад санхүүгийн байгууллагын олгосон нийт зээлийн багцын 5-аас доошгүй хувийг ногоон зээлээр бүрдүүлэх.

#	Зорилт	Арга хэмжээ	Манлайлан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
1-р бүлэг: Тогтвортой санхүүг хөгжүүлэх суурь нөхцөл, бодлогын орчныг бүрдүүлэх				
1	Тогтвортой санхүү, ногоон сэргэлт, тогтвортой шилжилтийн стратеги	<p>1.1. Үндэсний тогтвортой санхүүгийн стратегийг боловсруулж Улсын Их Хурал (УИХ)-д өргөн барьж, батлуулах, стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөв боловсруулах, холбогдох эх үүсвэрийг төсөв, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудаас татан төвлөрүүлэх.</p> <p>1.2. Эдийн засгийн гол салбаруудын дэд стратеги, уур амьсгалын хөрөнгө оруулалтын бодлого, зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэхэд холбогдох яам, агентлагуудтай хамтран ажиллах.</p>	СЯ, ЭЗХЯ, МБ, СЗХ, ХДК	1-2 жил
			БОАЖЯ, ЭЗХЯ, СЯ	3-5 жил

		<p>1.3. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд ногоон, тогтвортой санхүүжилтийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөг тодорхойлох.</p> <p>1.4. Уламжлалт нүүрс, газрын тос, байгалийн хийн салбарын хөрөнгө оруулалтыг цэвэр технологи, сэргээгдэх эрчим хүчний салбарт шилжүүлэх арга замыг судалж, боловсруулах.</p> <p>2.1. Стратегийг хэрэгжүүлэх засаглалын механизмыг тодорхойлж хяналтын хороо, дэд хороо, ажлын хэсгүүдийг бий болгох.</p> <p>2.2. Тогтвортой санхүүжилтийг дэмжигч олон улсын байгууллагуудын зөвлөлдөх платформ, ажлын хэсгийг байгуулах.</p>	ЭЗХЯ, СЯ	1-2 жил
2	Үндэсний тогтвортой санхүүгийн засаглалын механизм	<p>3.1. Үндэсний ногоон таксономид нийгмийн үр нөлөөтэй салбаруудыг нэмж оруулах, шинэчлэх.</p> <p>3.2. Таксономийн үндсэн салбар тус бүрээр нарийвчилсан удирдамж, шалгуур үзүүлэлтийг боловсруулах</p> <p>3.3. Үндэсний таксономийг Европын Холбоо, БНХАУ-ын Нэгдмэл ойлголт бүхий (Common Ground Taxonomy) Таксономитой уялдуулах, хөрөнгө оруулагчдын шаардлагад нийцүүлэх.</p> <p>3.4. Банк, банк бус санхүүгийн байгууллагуудаас ногоон/тогтвортой хөгжлийн таксономитой нийцүүлэн зээлийн статистик мэдээллийг авах, салбарын түвшинд нэгтгэн олон нийтэд танилцуулах.</p> <p>3.5. Ногоон/Тогтвортой хөгжлийн төслүүдийн үр дүн, нөлөөллийг хэмжих, тайлагнах аргачлалуудыг боловсруулах.</p>	УУХУЯ, ЭХЯ, СЯ, СЯ, ЭЗХЯ, МБ, СЗХ, ХДК СЯ, ЭЗХЯ СЯ, МБ, СЗХ, ХДК ТоС Холбоо, МБ, СЗХ, СЯ СЯ, МБ, СЗХ, ХДК МБ, СЗХ, ТоС Холбоо ТоС Холбоо, МБ, СЗХ, СЯ	3-5 жил 1-2 жил 1-2 жил 1-2 жил 1-2 жил 2-3 жил 1-2 жил 1-2 жил
3	Таксономи			

		3.6. Ногоон/тогтвортой хөгжлийг дэмжсэн гадаадын тусламж, шууд хөрөнгө оруулалтын урсгалыг бүртгэх системийг хөгжүүлэх.	ЭЗХЯ, СЯ	3-5 жил
4	Сургалт, судалгаа, олон улсын хамтын ажиллагаа	4.1.Тогтвортой санхүүгийн чадавх бэхжүүлэх цогц хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх.	МБ, СЗХ, СЯ, ТоС Холбоо	1-2 жил
		4.2. Ур чадварын шалгалт, албан журмын сертификаттай сургалтуудад тогтвортой санхүүгийн сургалтыг оруулах ажлыг зохион байгуулах.	МБ, СЗХ, СЯ	3-5 жил
		4.3. Судлаачид, санхүүгийн салбарынхны хооронд мэдлэг солилцох зорилготой Тогтвортой санхүүгийн судалгаа, шинжилгээний талбар байгуулах.	МБ	3-5 жил
		4.4. Тогтвортой санхүүжилтийг олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд сурталчлан таниулах.	МБ, СЗХ, СЯ, ХДК	1-2 жил
		4.5. Иргэд, бизнесүүдэд тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүний ач холбогдлыг таниулах тусгайлсан мэдлэг дээшлүүлэх компанид ажлыг зохион байгуулах.	МБ, СЗХ, СЯ, ХДК,	1-2 жил
		4.6. Олон улсын холбоо, платформ, хөтөлбөрүүдтэй хамтын ажиллагаа үүсгэх, эрчимжүүлэх, олон улсын тогтвортой санхүүгийн бодлогын хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцох.	МБ, СЗХ, СЯ, ХДК	үргэлжлэх
5	Хяналт, үнэлгээ	5.1. “Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ын явц, үр дүнг хэмжих Үндэсний хэмжээний уур амьсгалын санхүүжилтийн урсгалыг хянах платформ/аргачлал боловсруулах.	БОАЖЯ, ЭЗХЯ, СЯ	үргэлжлэх
		5.2. Ногоон/Тогтвортой хөгжлийн хөрөнгө оруулалтын зорилтыг хэрэгжүүлэхэд оролцож буй яамд, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудын гүйцэтгэлийг хянах, үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх.	ЭЗХЯ, СЯ	3-5 жил

	<p>5.3. Санхүүгийн байгууллагуудын тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтэд хяналт, мониторинг, үнэлгээний тогтолцоог бий болгох.</p> <p>5.4. Жил бүр шилдэг тогтвортой санхүүгийн байгууллага болон ногоон төсөл хэрэгжүүлэгчдийг тодруулж нийтэд мэдээлэх.</p> <p>5.5. Тогтвортой санхүүжилтийн үр өгөөж, санхүүгийн байгууллагуудын зан төлөвийн өөрчлөлтийг харуулах зорилгоор тогтвортой санхүүгийн хэрэгжилт, туршлагыг харуулсан олон жилийн дата мэдээллийг цуглуулж, судалгаа шинжилгээ хийх.</p>	МБ, СЗХ	үргэлжлэх	
2-р бүлэг: Төсөв санхүүгийн үйл ажиллагааг ногоон хөгжилд чиглүүлэх				
6	Хүлэмжийн хийн шимтгэл/татвар	6.1. Карбоны үнэ, татвар тогтоохтой холбоотой судалгааг хийж, боломжит хувилбаруудыг тодорхойлох.	УУХҮЯ, СЯ	3-5 жил
		6.2. Карбон солилцох, арилжих системийг хөгжүүлэх.	УУХЯ, БОАЖЯ СЯ,	5+ жил
		7.1. БОАЖЯ-ны ногоон татварын хөнгөлөлт/урамшууллын бодлогыг Үндэсний ногоон таксономитой уялдуулж, сайжруулах боломжийг судлах.	БОАЖЯ, СЯ,	3-5 жил
		7.2. Байгалийн бохирдлын төлбөр, татварын хууль эрх зүйн орчин, түүний зарцуулалтын ил тод байдлыг сайжруулах талаар судлах.	СЯ, БОАЖЯ	3-5 жил
7	Байгаль орчны татварын бодлогууд	7.3. Нөөц ашигласны болон бохирдуулсны татвар, хураамжийг зөв зохистой цуглуулах, дахин хуваарилах зорилгоор Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн удирдлагын журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг сайжруулах талаар судлах.	БОАЖЯ, СЯ,	3-5 жил
		7.4. Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн хараат бус, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан “Ногоон тэрбум итгэлцлийн сан” байгуулах.	БОАЖЯ, СЯ, МБХ	3-5 жил

8	Ногоон, тогтвортой төсвийн зарцуулалт, худалдан авалт	8.1. Ногоон худалдан авалтын журам, стандартыг нэвтрүүлэх. 8.2. Төрийн ногоон худалдан авалтын ил тод байдлыг сайжруулах.	СЯ, БОАЖЯ СЯ	3-5 жил 5+ жил
9	Өрийн своп /Debt swap/	9.1. Ногоон санхүүжилт болон уур амьсгалын өөрчлөлтийн өрийн своп нэвтрүүлэхэд чиглэсэн техникийн судалгааг хийж, боломжит хувилбаруудыг тодорхойлох.	МБ, БОАЖЯ, СЯ,	1-2 жил
3-р бүлэг: Ногоон, тогтвортой хөгжлийн, уур амьсгалын хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх				
10	Ногоон, тогтвортой хөгжил, уур амьсгалын санхүүжилтийн эрэлт, хэрэгцээ	10.1. Үндэсний тогтвортой/ногоон хөгжлийн бодлого, зорилтот салбаруудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийн дутагдал, зардлыг тооцох аргачлалыг боловсруулах, санхүүжүүлэх боломж, шийдлүүдийг тодорхойлох. 10.2. Засгийн газрын хөрөнгө оруулалт, төсвөөр санхүүжүүлэх ногоон/тогтвортой хөгжлийн төслүүд, уур амьсгалын санхүүжилтийн төсвийг тодорхойлох, үнэлэх, ач холбогдлын эрэмбээр ангилах аргачлалыг боловсруулах. 10.3. Төрийн болон хувийн хэвшлийн санхүүжилт шаардлагатай ногоон/тогтвортой хөгжлийн төслүүдийн жагсаалт, нэгтгэл гаргах.	МБ, ЭЗХЯ, СЗХ, СЯ СЯ, БОАЖЯ, ТоС Холбоо СЯ, ТоС Холбоо	1-2 жил 1-2 жил 1-2 жил
11	Ногоон, тогтвортой хөгжлийн зээл олголтыг дэмжих бодлого	11.1. Ногоон эх үүсвэр татах болон ногоон төслүүдэд олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор одоогийн СВОП хэлцлийн хөнгөлөлтийг нэмэгдүүлж, таатай нөхцөл нэвтрүүлэх боломжийг судлах. 11.2. Ногоон зээл олголтыг дэмжих зорилгоор активын эрсдэлээр жигнэх хувь хэмжээ, өр орлогын харьцаа, заавал байлгах нөөцийн хэмжээ, барьцаа хөрөнгийн шаардлагуудад өөрчлөлт оруулах боломжийг судлах.	МБ МБ, СЗХ	3-5 жил 3-5 жил

		11.3. ББСБ-дын нийт олгосон зээлийн 5-аас багагүй хувь нь ногоон зээлд олгох зохицуулалт, дэд бүтцийн орчныг бий болгох.	СЗХ	1-2 жил
		12.1. "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-д орсон ногоон бондын зохицуулалтын талаар бонд, үнэт цаас гаргагчдад танилцуулах.	СЗХ, СЯ	1-2 жил
		12.2. Ногоон/тогтвортой бонд гаргах (анхан шатны үнэлгээ хийх гэх мэт) болон баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэх, хөнгөлөлт олгох боломжийг судлах.	СЗХ, СЯ	3-5 жил
		12.3. Бонд гаргагч, хөрөнгө оруулагчдад зориулан ногоон/тогтвортой бондын татварын урамшууллыг нэвтрүүлэх талаар судлах.	СЯ, БОАЖЯ	3-5 жил
12	Ногоон, тогтвортой бонд гаргалтыг дэмжих бодлого	12.4. Ногоон/тогтвортой бонд гаргагчдад бүртгэлийн давуу эрх болон бүртгэлийн хураамжийн хөнгөлөлт олгодог болох.	СЗХ	1-2 жил
		12.5. Ногоон/тогтвортой бонд баталгаажуулагч дотоодын байгууллагуудад зориулсан заавар, гарын авлага, стандарт боловсруулах.	СЗХ	3-5 жил
		12.6. Ногоон/тогтвортой бондын батлан даалтын сан байгуулах боломжийг судлах.	СЗХ, СЯ	5+ жил
		12.7. Засгийн газрын ногоон/тогтвортой бонд гаргах боломжийг тодорхойлох техникийн судалгаа хийх.	СЯ	1-2 жил
		12.8. Засгийн газрын ногоон/тогтвортой бонд гаргах журам боловсруулах.	СЯ	1-2 жил
		12.9. Бондоор санхүүжүүлж болох ногоон/тогтвортой хөгжлийн төслүүдийн жагсаалт гаргах, хөгжүүлэх.	СЯ	3+ жил
13	Ногоон, тогтвортой хөгжлийн зээл олголтын хөтөлбөр	13.1. Ажлын байрыг дэмжих зээл, Орон сууцны ипотекийн зээл, Ноолуур хөтөлбөр, ЖДҮ сан зэрэг Засгийн газрын зорилтот хөнгөлөлттэй	МБ, СЯ	1-2 жил

		<p>хөтөлбөрүүдэд ногоон салбар/төслийг дэмжих, санхүүжүүлэх тусгайлсан квот, шаардлага тавих боломжийг судалж, санал боловсруулах.</p> <p>13.2. Сангийн яам болон Монголбанкны Ипотекийн зээлийн журамд эрчим хүчний хэмнэлттэй амины сууц, шинэ орон сууц, хуучин амины болон нийтийн сууцны дулаалгын арга хэмжээг хамруулан хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх асуудлыг судлан санал боловсруулах.</p> <p>13.3. Ногоон зээлийн хүүгийн татаасны хөтөлбөрийн цар хүрээ, эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх эсэх чиглэлээр судлан ажиллах.</p> <p>13.4. Зээлийн батлан даалтын сангийн хүрээнд ногоон батлан даалтын бүтээгдэхүүн хөгжүүлэх, нэвтрүүлэх.</p> <p>13.5. Олон улсын хөгжлийн банкуудаас ногоон зээлийн хөнгөлөлттэй эх үүсвэр татах боломжийг судлан, хамтран ажиллах.</p>	<p>МБ, СЯ</p> <p>СЯ, МБ, ЭЗХЯ</p> <p>СЯ, МБ, СЗХ</p> <p>СЯ, МБ, СЗХ</p>	<p>3-5 жил</p> <p>1-2 жил</p> <p>3-5 жил</p>
<p>14</p>	<p>Ногоон, тогтвортой хөгжлийг дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүн</p>	<p>14.1. Ногоон, уур амьсгалын санхүүгийн бүтээгдэхүүнүүд, санхүүгийн хэрэгслүүдийг стандартичлах боломжийг судалж, нэвтрүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, бизнесийн зээл - Ногоон/ТоХ-д чиглэсэн хэрэглээний болон бичил зээл - Ногоон/ТоХ-д чиглэсэн ЖДУ/бизнесийн зээл - Ногоон/ТоХ-д чиглэсэн цахим санхүүгийн бүтээгдэхүүн - Ногоон/ТоХ-д чиглэсэн ипотекийн зээл - Жендерийн мэдрэмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн - Бусад уур амьсгалын өрийн хэрэгслүүд 	<p>ТоС Холбоо, МБ, СЗХ,</p>	<p>3-5 жил</p>

	14.2. Ногоон таксономитой уялдсан ногоон технологийн мэдээллийн сан үүсгэж, ашиглах.	ТоС Холбоо, МБ, СЗХ	1-2 жил
	14.3. Ногоон туршилтын төслүүдийг хэрэгжүүлэх.	ТоС Холбоо, МБ, СЗХ	3-5 жил
	14.4. Ногоон төслүүдийн ТЭЗҮ, шалгуур, хэмжилт, үнэлгээний аргачлал болон баталгаажуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх техник тусалцааны төв/инкубатор байгуулах.	ТоС Холбоо, СЯ	3-5 жил
	14.5. Үндэсний ногоон шошгожуулалтын стандартыг шинэчлэх, салбар тус бүрийн онцлог тохирсон шошгожуулалтын журам, шалгуур, нөлөөллийг хэмжих аргачлал гаргах.	ТоС Холбоо, БОАЖЯ	3-5 жил
	14.6. Ногоон шошго/сертификат олгох хараат бус тогтолцоог бий болгох.	ТоС Холбоо, БОАЖЯ	3-5 жил
	14.7. Аж ахуйн нэгж, бүтээгдэхүүнүүдийг шат дараатайгаар ногоон шошгожуулалтад хамруулах.	ТоС Холбоо, БОАЖЯ	5+ жил
15	Ногоон даатгал	СЗХ, ТоС Холбоо	5+ жил
16	Ногоон финтек	МБ, СЗХ, ТоС Холбоо	2-3 жил
17	Жендерийн мэдрэмжтэй санхүүжилт	ТоС Холбоо, МБ, СЗХ	1-2 жил
4-р бүлэг: Ногоон банк, санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх			
18	Монголын ногоон санхүүгийн корпораци	НЗДТГ	1-2 жил
		НЗДТГ, МБ, СЗХ, СЯ	1-2 жил

	эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр судлан ажиллах.		
19	Төрийн өмчит байгууллагууд	18.3. Монголын ногоон санхүүгийн корпорацид ногоон хөрөнгийн урсгалыг олон талаас татан төвлөрүүлэх. 19.1.Төрийн өмчит санхүүгийн байгууллагуудад тогтвортой санхүүгийн бодлого, стратегийг нэвтрүүлэх. (Төрийн банк, Монгол Улсын Хөгжлийн банк, ХДК, Зээлийн батлан даалтын сан болон бусад) 20.1. Хөгжлийн банк, МИК, Зээлийн батлан даалтын сан зэрэг байгууллагуудад тогтвортой санхүүжилтийн стратеги нэвтрүүлэх. 20.2. Банкнуудад ногоон банкны бодлого нэвтрүүлэх туршлага, боломжийг судлах.	НЗДТГ, МБ, СЗХ, СЯ СЯ, ХДК СЯ, ТоС Холбоо МБ, ТоС Холбоо
20	Санхүүгийн байгууллагууд		3-5 жил 3-5 жил 2-3 жил 2-3 жил
5-р бүлэг: Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ), уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах			
21	БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо	21.1. Банкны бус санхүүгийн байгууллагуудад зориулсан БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын зөвлөмж, загвар, аргачлал боловсруулах. 21.2. Хөрөнгийн удирдлагын компаниудад зориулсан БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын зөвлөмж, загвар, аргачлал боловсруулах. 21.3. ОССК-дад зориулсан БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын зөвлөмж, заавар, аргачлал боловсруулах. 21.4. Банкны үйл ажиллагаанд заавал мөрдөх шинжтэй БОНЗ-ын болон уур амьсгалын эрсдэлийн удирдлагын журам, шаардлагуудыг судлах, шаардлагатай тохиолдолд нэвтрүүлэх. 21.5. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын үйл ажиллагаанд зээлийн скоринг хийхэд БОНЗ-ын үзүүлэлтийг тусгах боломжийг судалж, шаардлагатай тохиолдолд зөвлөмж заавар боловсруулах.	ТоС Холбоо, СЗХ ТоС Холбоо, СЗХ ТоС Холбоо МБ МБ

	21.6. БОНЗ-ын тайлагналд гуравдагч талын хөндлөнгийн баталгаа гаргадаг мэргэшсэн байгууллага байгуулах.	ТоС Холбоо, СЯ	5+ жил
	21.7. Санхүүгийн байгууллагууд зориулсан БОНЗ-ын эрсдэлийн зэрэгтэй уялдсан зээлийн эрсдэл, өгөөжийг бүртгэх туршлагыг судлах, шаардлагатай тохиолдолд удирдамж боловсруулах.	МБ, СЗХ, ТоС Холбоо	2-3 жил
	22.1. Нүүрсний салбар ба уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн төлөв, олон улсын хандлага ба бодлого, тэдгээрээс Монгол Улсын эдийн засагт богино, урт хугацаанд үзүүлэх нөлөөг судлах.	УУХҮЯ, ЭЗХЯ, МБ	1-2 жил
	22.2. Санхүүгийн байгууллагын багц болон уур амьсгалын нөлөөлөл ихтэй салбаруудыг тодруулах, тэдгээрт стресс тест, сценарио шинжилгээ хийх.	МБ, СЗХ	3-5 жил
	22.3. Монгол Улсын Тогтвортой санхүүгийн зарчмуудад уур амьсгалын эрсдэлийг тусган шинэчлэх.	ТоС Холбоо, МБ, СЗХ	1-2 жил
22	Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоо	ТоС Холбоо, МБ, СЗХ, СЯ	2-3 жил
	22.4. Санхүүгийн салбарын хөрөнгө оруулалт, зээлд хамаарах хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол хийх аргачлал боловсруулах.	МБ, СЗХ	2-3 жил
	22.5. Санхүүгийн салбарт уур амьсгалын эрсдэлийн үнэлгээг хийх аргачлалыг боловсруулах.	ТоС Холбоо, МБ, СЗХ	2-3 жил
	22.6. Санхүүгийн байгууллагууд, компаниудад зориулан уур амьсгалын өөрчлөлтийн бодлого нэвтрүүлэх аргачлалыг боловсруулах.	ТоС Холбоо, МБ, СЗХ	2-3 жил
	22.7. Санхүүгийн байгууллагуудад зориулсан хүлэмжийн хий бууруулах зорилт тавих аргачлал боловсруулах.	ТоС Холбоо, МБ, СЗХ	3-5 жил
6-р тулгуур: Ил тод, нээлттэй тайлагналыг дэмжих			
23	Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын шаардлагыг тусгах.	СЗХ, МХБ	2-3 жил

24	БОНЗ-ын эрсдэлийн тайлагнал Санхүүгийн байгууллагуудын тогтвортой байдлын тайлагнал	<p>23.2. Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад зориулан БОНЗ-ын ил тод байдал, тайлагналын гарын авлага боловсруулах.</p>	СЗХ, МХБ, ТоС Холбоо	1-2 жил
		<p>23.3. Салбар бүрийн онцлог тохирсон БОНЗ-ын үйл ажиллагааны жишиг, индикаторуудыг тогтоож, БОНЗ-ын гүйцэтгэл сайтай компаниудын тусгай самбар бий болгох.</p>	СЗХ, МХБ, ТоС Холбоо	3-5 жил
		<p>23.4. БОНЗ-ын тайлагнал сайн хийдэг компаниудад зориулсан урамшууллын тогтолцоо бий болгох.</p>	СЗХ	3-5 жил
		<p>23.5. Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад зориулж мэдлэг хуваалцах, туршлага солилцох, чадавх бэхжүүлэх платформ бий болгох.</p>	СЗХ	3-5 жил
		<p>24.1. Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлийн олон улсын стандартуудад нийцсэн тогтвортой хөгжлийн тайлагналын заавар, зөвлөмжийг санхүүгийн байгууллагуудад зориулж боловсруулах.</p>	ТоС Холбоо, МБ, СЗХ	2-5 жил
		<p>24.2. Жендерийн үнэлгээний аргачлалыг бүх санхүүгийн байгууллагад нэвтрүүлж, хүйсээр ангилсан дата мэдээллийг санхүүгийн байгууллагуудаас тогтмол авах, нэгдсэн статистик гаргах тогтолцоо бүрдүүлэх.</p>	СЗХ, СЯ	үргэлжлэх

---oOo---